



Хэвлэл Мэдээллийн Зөвлөл

2015-2018 оны товч тайлан, танилцуулга

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийг үүсгэн байгуулах чуулганаар салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын дүрмийн төслийг танилцуулж, чуулганд оролцогчид санал нэгтгэйгээр баталсан. Ийнхүү “ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ” НҮТББ-ыг 2015 оны нэгдүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо байгуулсан юм.

Тухайн үеийн "Засгийн газрын мэдээ" сонины Ерөнхий эрхлэгч С.Батбаатар Монголын хэвлэл мэдээллийн салбарт түүхэн үйл явдал тохиож буйг онцолсон бол МХЧБФ-ын тэргүүн У.Тамир энэхүү зөвлөл байгуулагдсанаар сэтгүүлчдийг шүүхийн хаалга татахаас сэргийлэх, олон нийтийн мэдэх эрхийг хангах, сэтгүүлчдийн ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх зэрэг олон талын ач холбогдолтойг онцолж байв.

Зөвхөн 1999-2011 оны хооронд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчийн эсрэг 297 иргэний, 16 эрүүгийн хэрэг шүүхээр орж байсан байна.

ӨДРИЙН ҮЙЛ ЯВДАЛ

СЭТГҮҮЛ ЗҮЙ

МОНГОЛЫН СЭТГҮҮЛЧИД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛТЭЙ БОЛЛОО

Х.БОЛОР

Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбарт анх удаа Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулагдлаа. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах, сэтгүүлчдийг хамгаалахад дэмжлэг үзүүлж, энэ салбарт хариуцлага, ёс зүйг төлөвшүүлэн, үнэнийг мэдэх гэсэн ард түмний эрхийг хамгаалж, хэвлэл мэдээллийнхэнд дөрвөн дэх засаглалын үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэх боломж олгох нь Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үндсэн үүрэг. Энэ үүргээ гүйцэтгэхийн тулд тус зөвлөлийн 45 гишүүн өчигдөр анхны хурлаа хийж, байгууллагынхаа дүрмийг батлав. Хэвлэл мэдээллийн зөвлөл нь нийтэд үйлчилдэг, өөрийн зохицуулалттай, улс төр, эдийн засгийн аливаа бүлэглэлээс хараат бус, байнгын ажиглагатай төрийн бус байгууллага байх юм. Байгууллага нь дотроо Удирдах зөвлөл, Сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороо, Радио, телевизийн ёс зүйн хороотой. Удирдах зөвлөл болон хоёр хорооны гишүүдийг энэ сарын 23-27-нд Улаанбаатар хот, орон нутагт болсон салбар



хурлуудаас сонгосон юм. Гишүүдийг сонин, нутгийн, санаачигчдын бүлэг гэсэн таван хэсгээс сэтгүүлийн, радио, телевизийн, сайтын, орон хэвлэл мэдээллийн салбарынхан өөрсдөө

сонгосон. Эдгээр гишүүн хурлаар батламжилж, сэтгүүл, сайтын болон зүйн хорооны дарга нар Хэвлэл мэдээллийн хууль" нь Сэтгүүлчдийн зөвлөл нь сонин, сэтгүүлд цацагдсан мэдээг гэрэл зураг, дүрсгүй хэргийг авч, Сэтгүүлчийн ёс зүйн асуудлаар дэмжлэг үзүүлж, гэрэл зураг мэдээ, нийтлэл, нэвтрүүлэг зэрэгчээ гэж үзвэл оноо залруулга гаргах шийдвэр иргэд хэвлэл мэдээ холбоотой аливаа гомд мэдээллийн зөвлөлд гүйцэтгэх шүүх байгууллага ачаалал багасгахад гүйцэтгэх асуудлыг Эрүүгийн хууль, асуудлыг илүү мэдээ, шударгаар шийдвэр давуу талтай.

Хэвлэлийн эрх чөлөөний төлөөх хорь гаруй жилийн дараа хэвлэл мэдээллийн ёс зүйн стандартыг хараат бусаар тогтоож, мөрдүүлэх өөрийн зохицуулалтын байгууллага бий болоод дөрвөн жил болжээ. 2015 оны нэгдүгээр сарын 28-нд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын эзэд, удирдлагууд, мэргэжлийн байгууллага, эвсэл холбоодын хамтын ажиллагааны үр дүнд Хэвлэл Мэдээллийн Зөвлөл байгуулагдсан билээ.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөө байгуулснаар ёс зүйн үндсэн зарчмуудыг аливаа ашиг сонирхлоос холуур, хамтын хуралдааны зарчмаар шийдвэрлэдэг журмыг бид тогтоосон. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим нь хүний эрхийг дээдэлдэг манай улсын бүхий л талбарт хүчинтэй. Сайн дурын өөрийн зохицуулалтын бүтэц, үйл ажиллагаа маань үр дүнгээ өгч, цаашид улам илүү түгэхийг дөрвөн жилийн туршлага харуулж байна.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын дүгнэлт нь сэтгүүл зүйн өдөр тутмын ажилд чанарын хэмжүүр, хэм хэмжээг тогтоож байна. Ирээдүйд өөрийн хяналт нь урд өмнө байснаасаа ч илүү чухал болно. Энэхүү өөрийгөө хянах тогтолцоогоороо Хэвлэл Мэдээллийн Зөвлөл сэтгүүлчдийг төрийн эсвэл аль нэг хүчний хяналт, дарамтад орохоос, нөгөөтэйгүүр иргэдийг хуурамч мэдээлэл авахаас хамгаална.



Ч.Номин

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын салшгүй оролцогч нь уншигч, үзэгч, сонсогчид юм. Учир нь Хэвлэл мэдээллийн зөвлөл хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ажиглан, тэдэнд хяналт тавих үүргийг өөртөө бий болгодоггүй. Харин энэ үүрэг уншигч, сонсогч, үзэгчдэд байдаг юм.

Г.Гунжидмаа

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Хэрэв ёс зүйн зарчмыг зөрчиж байгаа явдал нь үндэслэлтэй бол хувь хүн өөрөө тухайн асуудалд холбогдолгүй байсан ч өргөдөл, гомдлоо Хэвлэл мэдээллийн зөвлөлд гаргах эрхтэй. Энэхүү хянах үүргийг гүйцэтгэж байдгаараа иргэд ил тод байдал, ардчилсан нийгмийн соёлын чухал элементийг харуулдаг.

Өнгөрсөн хугацаанд Хэвлэл мэдээллийн зөвлөлд уншигч, сонсогч, үзэгчдээс 212 хэвлэл мэдээллийн байгууллагад хаягласан гомдлыг илгээжээ. Тэд редакц, сэтгүүлчид гаргасан гомдлоо шүүх, цагдаад гэхээс илүү салбарын өөрийн зохицуулалтын байгууллагыг сонгож байна.

Сэтгүүл зүйн салбарынхан ёс зүйн дүрэмгүй нийгмийн сүлжээнийхнээс ялгарах гол үндсэн чиг луужин нь Хэвлэл Мэдээллийн Ёс зүйн Зарчим юм. Сэтгүүл зүйн чанартай бүтээл, түүнийг хүлээн авснаараа иргэд амьдралдаа зөв шийдвэр гаргах үйл явцад Хэвлэл Мэдээллийн Зөвлөл үргэлж эрэлт хэрэгцээтэй түнш тань байх болно.

Хэвлэл Мэдээллийн Зөвлөл нь анх байгуулагдахдаа доорх таван бүлгээс ижил тэнцүү тооны төлөөлөгчид тус тусын салбар хуралдаанаас Удирдах зөвлөл болон Ёс зүйн хороод сонгогдсон юм. Салбар бүрт сэтгүүлч болон эрхлэн гаргагчийн төлөөлөл тэнцүү байна.

Удирдах
зөвлөл

15 гишүүн

Дарга
Ч.Номин

Сонин, сэтгүүл,
сайтын хороо

15 гишүүн

Дарга
Ж.Батбаатар

Радио,
телевизийн
хороо

15 гишүүн

Дарга
Ш.Сүхбаатар



Ажлын алба

Гүйцэтгэх захирал
Г.Гүнжидмаа

Info@mediacouncil.mn
7000-0160

Сонин, сэтгүүл

Сайт


Санаачлагын
бүлэг

Орон
нутаг

Телевиз,
радио


Гомдол хүлээн авах

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зориулан цацсан тодорхой мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлэг зэрэг сэтгүүл зүйн бүтээлтэй холбоотой гомдлыг хүлээж авна




Хариу тайлбар

Гомдолд хаяглагдсан ХМБ-д гомдлын талаар мэдээллийг хүргүүлж, ажлын 5-10 хоногийн дотор хариу тайлбар хийх боломжийг олгоно



Ёс зүйн хороо хуралдана


Тухайн бүтээлд хийсэн шинжилгээ, хэлэлцүүлэг, мэтгэлцээний үр дүнд үндэслэн сэтгүүл зүйн ёс зүй, мэргэжлийн хэм хэмжээний алдаа зөрчил гаргасан эсвэл гаргаагүй гэсэн дүгнэлт гаргана



Ёс зүйн хорооны шийдвэр


- Зөрчил гаргаагүйг мэдэгдэх
- Зөрчлөө өөрсдөө залруулсныг мэдэгдэх
- ХМБ-ын нэрийг дурьдаж, зөрчлийг мэдээлэх, зөвлөмж хүргүүлэх

*аль тохирох шийдвэрийг гаргана



Хэлэлцэхгүй


- ❖ Хэвлэл мэдээлэлтэй холбоотой бусад, ерөнхий агуулгатай
- ❖ Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой
- ❖ Сэтгүүлчийн мэдлэг боловсрол, биеэ авч явах байдалтай холбоотой
- ❖ Арилжааны нэвтрүүлэг, зар сурталчилгаатай холбоотой



Статистик

Гомдлын тоо жилээс жилд өссөөр байна


Хамгийн сүүлийн үеийн буюу 2018 оны 10 дугаар сарын байдлаар нийт хүлээн авсан гомдлын тоо 86 байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулахад тасралтгүй өссөн дүн юм. Энэ нь иргэд редакцийн эсрэг гомдлоо шүүх, цагдаад гаргахаас илүү өөрийн зохицуулалтын байгууллагыг сонгож буйг харуулж байна.



Гомдол гаргагч хэн бэ?


Нийт гомдлын 85% нь сонин, сэтгүүл болон мэдээллийн цахим сайтуудад, 15% нь телевизүүдэд хаяглагджээ.

ХМЗ-д иргэдээс тэр дундаа төрийн албан хаагчдаас хамгийн олон удаа гомдол ирүүлсэн байна.



Алдаа хийхийг тойрохын аргагүй, харин алдаанаасаа суралцахгүй байхыг уучлахын аргагүй.

Гомдол шийдвэрлэсэн байдал



Ёс зүйн түгээмэл алдаа

Мэдээллийг нягтлаж шалгадаггүй	68
Олон эх сурвалжаар баталгаажуулдаггүй	50
Гарчиг, зураг, ишлэл нь агуулгыг буруугаар ойлгуулахгүй	41
Хувийн мэдээлэлд хүндэтгэлтэй ханддаггүй	34
Буруутгагдсан этгээдэд тайлбар хийх боломж олгодоггүй	30
Таамаг, цуу яриаг нийтэлж нэвтрүүлдэг	25
Шүүх гэм буруутайг нотлоогүй байхад гүтгэн доромжлохгүй	27
Мэдээлэх, эс мэдээлэхийн тулд авлига авахгүй	5

2015.01.28

Хэвлэл
мэдээллийн
зөвлөлийг
байууллаа

2015.04.14

“Хэвлэл
мэдээллийн
ёс зүйн
зарчим”,
“Гомдол
хүлээж
авах,
барагдуулах
журам”-ыг
батлав

2014.01.28

Хэвлэлийн
зөвлөл
байгуулах
санаачилгын
бүлэг үүсч
жилийн турш 7
хоног бүр
уулзалт хийв

2015.04.22

Иргэдээс
сэтгүүл зүйн
бүтээлийн
ёс зүйтэй
холбоотой
гомдлыг
өргөдөл
бичгийн
хэлбэрээр
хүлээн авч
эхэлсэн

2016.04.14

15 аймгийн
ХМБ-ын
удирдлага
сэтгүүлч
нийт 55 хүн
оролцсон
сургалтыг
Өмнөговь
аймагт хийв

2016.06.11

Ес зүйн
хорооны
гишүүдийг
чадавхжуулах
кейс
менежмент
сургалтыг
хийв.

2017.02.07

Хуульчдад
сургалт
зохион
байгууллаа

2017.08.12

Сэтгүүл
зүйн
хөгжлийн
чиг
хандлага,
ёс зүй
сургалтыг
Увс аймагт
хийв

2017.10.03

Сэтгүүл зүйн ёс
зүйн форумыг
анх удаа
зохион
байгуулав

JEF-2017

2018.09.21

Цахим сайтууд
дахь үзэн
ядалтын үг
хэллэгийн
судалгааны
дүнг
танилцуулав

2018

Хэвлэл
мэдээллийн
бодлого

Цуврал
хэлэлцүүлгээр
үтгэх зөрчлийн
талаар
хэлэлцэв

2018.10.23

Сэтгүүл зүйн ёс
зүйн форумыг
хоёрдахь удаагаа
зохион байгуулав


JEF-2018

Үйл явдлын товчоон



СЭТГҮҮЛЧИД БОЛОН
ОЛОН НИЙТЭД
ЗОРИУЛСАН
СУРГАЛТ,
КОМПАНИТ АЖЛУУД

Тоон мэдээлэл



*Хөвсгөл, Дорноговь, Увс, Дорнод, Эрдэнэт, Өмнөговь аймагт бүсчлэн хийсэн.



Та гомдол гаргахыг

ЗЭЛ

+976-7000-0160 

info@mediacouncil.mn 

Монгол ТВ тауэр, 1102 